

“ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЛИЙН ХАРААТ БУС БАЙДЛЫН СУДАЛГАА”-НД  
ХИЙСЭН АЖИГЛАЛТ, ДҮГНЭЛТ

М.Зулькафиль\*

\*МУИС-ийн Сэтгүүл зүй, олон нийтийн харилцааны тэнхимийн профессор, шинжлэх ухааны доктор (Sc.D)

**Түлхүүр үгс:** либертари онол, нийгмийн хариуцлагын онол, хэвлэлийн эрх чөлөө, чөлөөт хэвлэлийн шалгуур, цагдан хяналт, редакцын хараат бус байдал.

Сүүлийн жилүүдэд сэтгүүл зүй судлаачдын эгнээ өргөжиж, тэр хэмжээгээр ОНМХ-ийн түүх, онол, практикийн янз бүрийн асуудлыг хөндсөн бүтээлийн тоо ч нэмэгдэх хандлагатай байгаа нь Монголын сэтгүүл зүй судлал дахь эерэг үзэгдлийн нэг юм. Хамгийн гол нь түүх, онолын судалгааны бүтээлүүдийн сэдвийн хүрээ өргөжиж, “Монголын нууц товчоо”-гоос эхлээд өнөөдрийн чөлөөт хэвлэлийн хөгжлийн нэлээд ээдрээтэй асуудлуудыг хүртэл судлагдахуун болгон авч, цаашид анхаарч үзүүштэй үнэ цэнтэй үнэлэлт, дүгнэлт өгч байгаа нь дэмжүүштэй эхлэл гэдгийг онцлон хэлэх хэрэгтэй. Тийм шинэлэг бөгөөд нэлээд нарийн төвөгтэй сэдвийг сонгон авч эрдмийн зэрэг горилсон нэг сэдэвт бүтээлийн түвшинд судалгаа хийсэн ажил бол сэтгүүл зүйн доктор, судлаач Т.Батзоригийн 2019 онд хэвлэгдэн гарсан “Монголын хэвлэл мэдээллийн хараат бус байдлын судалгаа” хэмээх бүтээл юм.

Энэ ном бол дээрх сэдвээр бичигдсэн анхны бүтээл бөгөөд урьд өмнө судалгааны эргэлтэд ороогүй байсан маш их баримт, мэдээллийг анх удаа судалгааны эргэлтэд оруулж, нэг сэдэвт бүтээлийн хэмжээнд задлан шинжилж, нэгтгэн дүгнэж, үнэлэлт дүгнэлт өгч, цаашид анхаарч үзүүштэй санал зөвлөмж дэвшүүлснээрээ чухал ач холбогдолтой болжээ. Хамгийн гол нь орчин үеийн монголын ОНМХ-ийн нэн тулгамдсан асуудлын нэг болох редакцын хараат бус байдлыг дагнан судалж, энэ сэдвийг цаашид олон талаас нь гүнзгийрүүлэн судлах эхлэлийг тавьж байгаагаараа үнэ цэнтэй юм.

Хэвлэл мэдээлэл хараат байгаа тохиолдолд чөлөөт хэвлэлийн тухай ярих, төсөөлөх боломжгүй. Энэ асуудлыг хөндөнө гэдэг бол хүссэн, эс хүссэн ч чөлөөт хэвлэлийн хамгийн гол шалгуурын тухай ул суурьтай ярина гэсэн үг. Тийм учраас энэ бол хамрах хүрээ нь өргөн, судлаачаас багагүй хүч хөдөлмөр, цаг хугацаа, уйгагүй эрэл хайгуул, тодорхой дадал, туршлага шаарддаг сэдэв гэдэг нь тодорхой. Миний бие энэ сэдвийг судлахыг цөөнгүй магистрант, докторантад санал болгож байсан ч зориг гарган барьж авах хүн гараагүй

юм. Харин судлаач Т.Батзориг ийм хүнд сэдвийг сонгон авч Монголын хэвлэл мэдээллийн хараат бус байдлын асуудлыг хөндсөн өргөн хүрээг хамарсан судалгаа хийж, баримт мэдээлэл, үнэлэлт дүгнэлт сайтай, цаашид хэвлэл мэдээллийн практикт хэрэгжүүлэх боломжтой санал зөвлөмж бүхий чамбай нэг сэдэвт бүтээл туурвисныг талархан дэмжиж байгаага онцлон хэлье.

Хэвлэл мэдээллийн хараат бус байдал гэдэг нь өргөн утгаараа тухайн орны хэвлэл мэдээлэл чөлөөтэй, эс чөлөөтэй эсэхийг тодорхойлох шалгуур гэдэг нь ойлгомжтой. Учир нь дэлхийн “Фридом форум”, “Фридом наус”, “Хил хязгааргүй сэтгүүлчид” зэрэг бие даасан нөлөө бүхий байгууллагуудын шинжээчид аливаа орны чөлөөт хэвлэлийн рейтингийг тогтоохдоо төрийн мэдлийн бус хэвлэл мэдээллийн хэрэгсэл бий эсэх, улстөрч, өндөр албан тушаалтнууд, нөлөө бүхий бизнесменүүдийг шүүмжилж болох эсэх, ОНМХ-д үзүүлэх улс төрийн болон эдийн засгийн ил, далд дарамт шахалт байгаа эсэхийг харгалзан үздэг нь санамсаргүй хэрэг биш юм. Дээрх шалгуурыг бүрэн хангаж чадахгүй байгаа учраас манай орон олон жилийн турш “хагас чөлөөт хэвлэлтэй” орны ангилалд эргэлдсээр байгаа юм. Тиймээс миний бие зохиогчийн “Монгол Улс 1990 оноос ардчилсан нийгмийн тогтолцоог сонгож, хүний эрх, эрх чөлөөг дээдлэн, хэвлэлийн эрх чөлөөг хангахын тулд чөлөөт хэвлэлийг хөгжүүлэх эрх зүйн болон практик бүхий л талын бололцоог бүрдүүлэн өнөөг хүрсэн ч олон улсын байгууллагуудаас гаргадаг хэвлэлийн индексээр “хагас эрх чөлөөт” орон гэж дүгнэгдэж ирсэн нь хэвлэл мэдээллийн бие даасан, хараат бус байдалд доголдол дутагдал байнга учирч ирсэнтэй шууд холбоотой юм.

Чөлөөт хэвлэлийн хөгжлийн түүхэнд үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө, хэвлэлийн эрх чөлөөнөөс эхлээд хэвлэлийн мэдээллийн улс төр, эдийн засаг, редакцын аль ч түвшинд шууд бус болон шууд хэлбэрээр төрөл бүрийн ил далд хяналт /цензур/-ын олон тохиолдол, үйлдэл гарч байсан нь дээрх байдалд нөлөөлсөн нь гарцаагүй юм” (Батзориг 2019) гэсэн дүгнэлттэй санал нэг байна. Судлаач дээрх сэдвийг хэвлэлийн хараат бус байдал, түүхэн хөгжлийн болон өнөөгийн хэвлэл мэдээллийн хараат бус байдлын түвшнийг тодорхойлох асуудлыг тусгасан “Хэвлэл мэдээллийн хараат бус байдал, түүний хөгжлийн асуудалд” хэмээх нэгдүгээр бүлэг, хэвлэл мэдээллийн хараат бус байдлыг хангах эрх зүйн зохицуулалт, редакцын хараат бус байдлыг хангах арга хэрэгслийн асуудлыг хөндсөн “Чөлөөт хэвлэлийн үйл ажиллагааны хараат бус байдлыг хангах зарим арга зам” гэсэн хоёрдугаар бүлэгт багтаан авч үзсэн нь судалгааны ажил логик дараалал, учир зүйн холбоо, арга зүйн хувьд нэлээд оновчтой болсныг харуулж байна.

**З**охиогч судалгааны ажлын нэгдүгээр бүлэгт “хараат бус” байдал хэмээх ойлголтыг сэтгүүл зүйн түүхэн хөгжлийн хэв маягуудтай холбон тайлбарлаж, судалгааны ажлын үзэл баримтлалыг дэвшүүлэн тавьж, манай оронд үндэсний сэтгүүл зүй үүсэж хөгжиж ирсэн түүхэн цаг үеүдэд хэвлэл мэдээллийн хараат бус байдал ямар байсныг нийгэм, эдийн засаг, улс төрийн тогтолцооны хоёр том үетэй холбон 1990 оноос өмнө болон хойно хэмээн зааглан авч үзсэн байна. “Хараат бус” хэмээх ойлголтыг тодорхойлохдоо Я.Цэвэл, Е.П.Прохоров, В.Щульц зэрэг дотоод, гадаадын эдэмтэн судлаачдын тодорхойлолт,

үзэл бодолд тулгуурлан “...хэвлэл мэдээллийн хараат бус байдал гэж ардчилсан сэтгүүл зүйн үнэт зүйлийг хөндлөнгийн нөлөөгүйгээр хэрэгжүүлэх эрх мэдэл мөн” (Батзориг 2019) гэсэн өөрийн тодорхойлолтыг өгсөн нь хэдийгээр өргөн утгатай боловч зарчмын хувьд зөв юм.

**С**удлаач хэвлэл мэдээллийн хараат бус байдлыг дэлхийн сэтгүүл зүйн шашны клерикал сэтгүүл зүй, авторитари сэтгүүл зүй /XVII-XVIII зуун/, либерал сэтгүүл зүй /XVIII-XIX зуун/, зөвлөлт маягийн коммунист сэтгүүл зүй /XX зуун/, нийгмийн хариуцлагатай сэтгүүл зүй /орчин үе/ зэрэг түүхэн хэв маягуудтай холбон тайлбарлаж, хэвлэлийг хорио цээрийг үндэслэн ил буюу шууд хянаж цагдах, хараат байлгах, хэвлэл бие даасан хараат бус байх, хатуу хяналт /цензур/-тай байх зэрэг хараат бус байдалд хандах хандлагуудыг тодорхой жишээ баримт, судлаачдын үзэл баримтлалд үндэслэн тайлбарласан нь арга зүй, логик дарааллын хувьд оновчтой болжээ. Мэдээж дээрх хандлагуудыг АНУ-ын эрдэмтэд Ф.С.Сиберт нарын “Хэвлэл мэдээллийн дөрвөн онол”-ын үзэл баримтлалтай холбон үзэхгүйгээр бүрэн гүйцэд тодорхойлох, үнэн зөв, ойлгомжтой тайлбарлах боломжгүй юм. Үүнийг судлаач гярхай ажиглаж, Ф.С.Сиберт, У.Шрамм, Т.Питерсон нарын боловсруулсан авторитари онол, либертари онол, нийгмийн хариуцлагын онол, зөвлөлтийн коммунист онолын үзэл баримтлалыг өөрийнхөө судалгааны ажлын үндсэн чиг шугам болгон баримталсан нь нэг сэдэвт бүтээлийн онол, арга зүйн үндэслэлийг оновчтой гаргахад нөлөөлсөн нь илт байна. Тэр тусмаа 70 жилийн турш зөвлөлтийн коммунист онолын дагуу хөгжиж, 1990-ээд оноос либертари онолыг барим-

талж эхэлсэн, XXI зууны эхнээс нийгмийн хариуцлагын онолыг баримтлахыг зорьж буй Монголын сэтгүүл зүйн хувьд дээрх онол, үзэл баримтлал ус агаар шиг чухал гэдэг нь ойлгомжтой юм. Үүнийг зохиогч “Үүсэж хөгжөөд 105 жил болж буй Монголын хэвлэлийн түүхийг өмнөх тоталитар дэглэмийн үе /1921-1990/, өнөөгийн арчилсан чөлөөт сэтгүүл зүй хөгжиж буй шинэ нийгмийн үе гэсэн заагаар авч үзэхдээ дээр дурдсан тоталитар дэглэмийн үеийн Зөвлөлт маягийн сэтгүүл зүй, ардчилсан нийгмийн тогтолцоонд үйлчлэх либертари сэтгүүл зүй болон нийгмийн хариуцлагын сэтгүүл зүйн онолын үзэл баримтлалыг тулгуур болгосон” (Батзориг 2019) гэж тэмдэглэсэнтэй санал нэг байна.

Судлаач тоталитар дэглэмийн үед хэвлэл мэдээллийн хараат бус байдалд сөрөг нөлөө үзүүлж байсан цагдан хяналт буюу “цензур”, түүнийг бүрдүүлж байсан тогтолцоог төр, засгийн зүгээс тавих хяналт ямар байсан эсэх /1/, эдийн засаг, санхүүгийн хувьд хараат бус байсан эсэх /2/, мэдээллийн хэрэгсэл иргэдийн үзэл бодлоо чөлөөтэй солилцох индэр нь болж чадаж байсан эсэх /3/ зэрэг гурван гол шалгуурын хүрээнд судлан шинжлэхийг зорилго болгосон нь зарчмын хувьд зөв байсан бөгөөд судалгааны ажлын хүрээ, парадигмыг тогтооход нөлөөлжээ. Тиймээс нэг сэдэвт бүтээлийн редактор профессор Ж.Батбаатарын “...Зөвлөлт маягийн сэтгүүл зүйн үеийн... хэвлэл мэдээллийг онцлог байдалд нь тохирох гурван шалгуураар, ...ардчилсан нийгмийн үеийн буюу Монголын чөлөөт хэвлэлийн хараат бус байдлыг бодитой харуулж чадах дөрвөн шалгуур үзүүлэлтийг гаргаж тус бүрийнх нь хамрах хүрээг тогтоосон нь Монголын хэвлэл мэдээллийн хараат

бус байдлыг мөн чанар, түүхэн зүй тогтлынх нь хувьд судлан шинжлэх арга зүйн зохистой үндэс болсон юм. Ингэж хэвлэл мэдээллийн хараат бус байдлыг тогтсон үзэл баримтлал хийгээд олон улсад чөлөөт хэвлэлийн индексийг тогтоодог нарийн шалгуур үзүүлэлтүүдийг жишиг болгон судалж өнөөгийн Монголын хэвлэл мэдээллийн салбарын хараат бус байдлын түвшнийг тодорхойлсноороо практик ач холбогдолтой” (Батзориг 2019) гэж дүгнэсэнтэй санал нэг бөгөөд зөвхөн практик ач холбогдол төдийгүй онол, арга зүйн ач холбогдол нь ч чухам үүнд оршино гэж үзэж байна.

Судлаач Монголын хэвлэл мэдээллийн хараат бус байдлыг дээрх гурван шалгуурын хүрээнд баялаг жишээ баримтад тулгуурлан судалж, “...өмнөх нийгмийн үед Монголын сэтгүүл зүй төрийн зүгээс “урьдчилсан”, “шууд”, “ил” цагдан хяналттай, тэрхүү цагдан хяналт нь институт болтлоо төгс зохион байгуулагдаж хэвлэлд хатуу цагдан хяналт тогтоож байжээ. ... Чөлөөт хэвлэлийн тогтсон шалгуур баримтлалаар нь авч үзвэл 1921-1990 он хүртэл манай улсын хэвлэл мэдээллийн салбар нь төр засаг, эдийн засаг, дэд бүтцийн хувьд “шууд хараат” байсан нь харагдаж байна” (Батзориг 2019) гэсэн дүгнэлт хийжээ. Коммунист тогтолцоонд байсан орны хувьд энэ нь хэдийгээр мэдээжийн зүйл боловч үүнийг зохиогч тодорхой жишээ баримтаар нотолж чадсан нь судалгааны бүтээлийн нэг ололттой тал гэж хэлэх үндэстэй юм.

Нэгдүгээр бүлгийн дараагийн хэсэгт хэвлэл мэдээллийн хараат бус байдлын асуудлыг төр засгаас хараат бус эсэх (хэвлэл мэдээллийн хууль эрх зүйн орчин, төр хэвлэл мэдээллийн хэрэгслийг эзэмшихийг хязгаарлах

асуудал, лиценз бүртгэл), редакцын хараат бус байдал хангагдаж буй эсэх (ХМХ-ийн эзэмшил, төвлөрөл, редакцын бие даасан байдал, хэвлэлийн эрх чөлөөний хүчин зүйлс), эдийн засаг, санхүүгийн хувьд хараат бус эсэх гэсэн шалгууруудын хүрээнд судалж “Шууд бус цагдан хяналт газар авч санхүүжилт, далд эзэмшил, нөлөөллийн замаар хэлбэр төрхөө өөрчилсөн болох нь харагдлаа. ...Монголын хэвлэл мэдээллийн хараат бус байдал ил, далд хэлбэрээр зөрчигдөж, бие даасан хараат бусаар ажиллах бололцоо бүрэн хангагдаагүй байна” (Батзориг 2019) гэсэн дүгнэлт хийжээ.

**Х**эрэв энэ бүлэгт 1921 оноос өмнө гарч байсан “Шинэ толь хэмээх бичиг”, “Нийслэл хүрээний сонин бичиг” сонины тухай цухас ч гэсэн дурдаад өнгөрсөн бол илүү үр өгөөжтэй, үнэ цэнтэй болох байсан. Учир нь дээрх сонинууд хараат, хараат бус байсан талаарх судлаачид, сонирхогчид, практик сэтгүүлчдийн ойлголт хараахан нэг мөр болоогүй байна. Нэрт сэтгүүл зүй судлаач, доктор Г.Дэлэг багшийн “...үнэн хэрэг дээрээ монголын сэхээтний хүчин чармайлтын ачаар уг хэвлэл эхлээд бараг хэнээс ч хамаарахгүй, биеэ даасан байдлаар гарч эхэлжээ” (Дэлэг 1965) гэж дүгнэснийг дэмжин профессор Л.Норовсүрэн, Т.Баасансүрэн, М.Зулькафиль нар “Шинэ толь хэмээх бичиг” харьцангуй бие даасан, чөлөөт хэвлэлийн шинжтэй, тухайн үеийн төр засагт сөрөг хүчний байр сууринаас ханддаг байсан гэж үздэг бол Б.Батбаяр (Баабар), Б.Галаарид зэрэг хүмүүс Өргөө дэх Оросын консулын газар болон Богд гэгээний засгийн газраас хараат үйл ажиллагаа явуулж байсан гэж үздэг. Тиймээс энэ талаарх хэвлэл мэдээллийн хараат бус байдлыг тусгайлан судалж байгаа хү-

ний үнэлэлт дүгнэлтийг мэдэх нь чухал ач холбогдолтой байсан юм.

Судалгааны ажлын хоёрдугаар бүлэг нь бүхэлдээ хэвлэл мэдээллийн хараат бус байдлыг хангах арга зам, боломжийн асуудалд зориулагджээ. Судлаач энэ асуудлыг хэвлэл мэдээллийн хараат бус байдлыг хангах эрх зүйн зохицуулалт (ХМ-ийн үйл ажиллагаанд төрөөс шууд нөлөөлөхийг хориглох зохицуулалт, бодлого зохицуулалтын байгууллагын хараат бус байдлыг хангах эрх зүйн зохицуулалт, мэдээлэл авах эрх, эрх чөлөөг хангах эрх зүйн зохицуулалт, ОНРТ-ийн хараат бус байдлын зохицуулалт, ХМ-ийн олон ургалч байдлыг хамгаалах эрх зүйн зохицуулалт, хараат бус байдлыг эдийн засгийн аргаар дэмжих зохицуулалт, сэтгүүлчийн мэргэжлийн үйл ажиллагааг хамгаалах эрх зүйн зохицуулалт), редакцын хараат бус байдлыг хангах арга хэрэгсэл (редакцын хараат бус байдлыг хангах эрх зүйн зохицуулалт, хараат бус байдлыг хангах өөрийн зохицуулалт) гэсэн хоёр сэдвийн хүрээнд авч үзсэн бөгөөд сонирхолтой баримт мэдээллээр баялаг, үнэлэлт дүгнэлт, дотоод логик холбоо сайтай, практик ач холбогдол өндөр, ОНМХ-ийн практик үйл ажиллагаанд анхаарч үзүүштэй санал зөвлөмж дэвшүүлсэн чамбай бүлэг болжээ. Энэ бүлэгт судлаач МҮОНРТ-ийн хараат бус байдалд шүүмжлэлтэй хандаж, түүний удирдлагын бүрэлдэхүүнийг Ерөнхийлөгч, УИХ, Засгийн газар санал болгож УИХ томилдог нь ОНРТ-ийн хараат бус байдалд шууд нөлөөлдөг, ОНРТ-ийн тухай хуульд “иргэний нийгмийн төлөөлөл” гэж хэн болох, хэрхэн нэр дэвшүүлэх үйл явцын тухай тодорхой заалт ороогүйн улмаас Ерөнхийлөгч, Засгийн газар, УИХ нь иргэний нийгмийн саналыг бүрэн хэрэгсээгүй

бөгөөд үүнээс хойш тус байгууллагын Үндэсний зөвлөлийн дараа дараагийн гишүүнийг төрийн бус байгууллагуудын өргөн оролцоогүйгээр, ил тод бусаар томилох практик тогтоод байна” (Батзориг 2019), “ОНРТ-ийн хараат бус байдлыг хангахын тулд тус байгууллагын удирдах дээд байгууллагын гишүүдийг томилох үйл явц улс төрийн болон бусад өрөөсгөл ашиг сонирхлоос хараат бус байх баталгааг бий болгож чадаагүй нь өнөөгийн ОНРТ-ийн үйл ажиллагааны хараат бус байдалд сөргөөр нөлөөлж байна” (Батзориг 2019) гэсэн дүгнэлттэй санал нэг байна. Чухам дээрх шалтгааны улмаас өнөөдөр МҮОНРТ сонгуульд ялсан намын бүрдүүлсэн төр засгийн дуу хоолой болж, хэдэн улстөрч, дарга нарыг магтан дуулдаг, аливаа асуудлын нэг талыг барьж туйлширдаг ил, далд PR-ын хэрэгсэл болон хувирсныг мэргэжлийн судлаач байтугай жирийн үзэгч болгон шүүмжилдэг нь нууц биш юм. Өнөөдөр ОНРТ-ийг олон нийтийн мэдээллийн хэрэгсэл гэж хэлэхэд туйлын бэрх. ОНРТ-ийн хуулиар хүлээсэн үүргээ биелүүлж чадахгүй байгаа гэвэл хэтрүүлэг болохгүй.

**Э**нэ бүлэгт дээрхийн адил гярхай ажиглалт, анхаарч үзүүштэй дүгнэлт, дэмжүүштэй санал зөвлөмж цөөнгүй байна. Харин дэвшүүлэн тавьсан, судалгаагаар баталж нотолсон зарим асуудлыг яаж шийдвэрлэх талаарх арга замыг зааж өгөх талаар учир дутагдалтай байгааг хэлэх хэрэгтэй.

Дээр дурдсаныг нэгтгэн дүгнэвэл доктор Т.Батзоригийн “Монголын хэвлэл мэдээллийн хараат бус байдлын судалгаа” нэг сэдэвт бүтээл нь орчин үеийн ОНМХ-ийн онол, практикийн тулгамдсан асуудлыг нэг болох чөлөөт хэвлэлийн хөгжлийн амин сүнс болсон

хэвлэл мэдээллийн хараат бус байдлын асуудлыг цаг хугацаа, хамрах орон зайн хүрээнд түүхчлэн үзэх, харьцуулан судлах, задлан шинжлэх нэгтгэн дүгнэх, социологийн болон бүтэц-үүргийн аргаар судалж, шинжлэх ухааны үндэслэл бүхий үнэлэлт өгч, дүгнэлт хийсэн, чөлөөт хэвлэлийн хөгжилд чухал нөлөө үзүүлэхүйц практик зөвлөмж, үнэтэй санал дэвшүүлсэн чамбай бүтээл болжээ. Энэ сэдвийг цаашид гүнзгийрүүлэн судлах эхлэлийг тавьж, сэтгүүл зүйн судлалд үгүйлэгдэж буй орон зайг нөхөхөд чухал хувь нэмэр оруулж байгаад судлаач Т.Батзоригийн бүтээлийн үр өгөөж, практик ач холбогдол нь оршино.

#### Эшлэл

1. Батзориг Т. 2019. Монголын хэвлэл мэдээллийн хараат бус байдлын судалгаа. УБ., х.9.
2. Мөн тэнд. х.21.
3. Мөн тэнд. х.34.
4. Мөн тэнд. х.4.
5. Мөн тэнд. х.65.
6. Мөн тэнд. х.140.
7. Дэлэг Г. 1965. Монгол тогтмол хэвлэлийн түүхэн тэмдэглэл. УБ. х.66.
8. Батзориг Т. 2019. Монголын хэвлэл мэдээллийн хараат бус байдлын судалгаа. УБ., х.169.

9. Мөн тэнд. х.233.

#### Ашигласан бүтээлийн жагсаалт

1. Баасансүрэн Т. 2021. Монголын чөлөөт хэвлэл ба сэтгүүл зүйн шүүмж судлал, тулгамдсан зарим асуудал. УБ.
2. Батзориг Т. 2019. Хэвлэл мэдээллийн хараат бус байдлын судалгаа. УБ.
3. Дэлэг Г. 1965. Монгол тогтмол хэвлэлийн түүхэн тэмдэглэл. УБ.
4. Зулькафиль М. 2015. Орчин үеийн сэтгүүл зүй. УБ.
5. Зулькафиль М. 2016. Сэтгүүл зүйн онолын үндэс. УБ.
6. Зулькафиль М. 2018. ОНМХ-ийн судалгаа: онол, практик, арга зүй. УБ.

#### Summary

In this review, the author aims to assess T. Batzorig's monograph "Research on Media Independence" and demonstrate its achievements and shortcomings. Moreover, the author discusses the practical importance of media independence, which is one of the important indicators of free press, and critiques some of the conclusions and recommendations made by the researcher. The author concludes that this is the first work on media independence and that it plays a significant role in setting the foundation for further in-depth study of this topic.